

**“БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ  
ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ”-ЫН  
ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ**

2021.05.06

Улаанбаатар хот

№	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй журмын зүйл, хэсэг, заалт	Журмын шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалт	Шинэчилсэн үндэслэл, тайлбар
<b>Нэг. Өөрчлөн найруулсан</b>			
1	1.1. Энэхүү журмын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан төлбөрийн орлогын хэсгийг (байгалийн ургамал, ус, рашаан, ой, амьтны нөөц, <b>тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах</b> ) бүрдүүлэх, төсвийн зарлагад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөх, зарцуулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1.1. Энэ журмын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ байгалийн ургамал, амьтан, <b>газар</b> , ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлэх, төсвийн суурь зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусгах, зарцуулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	“... тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах ...” гэж заасныг газар гэж өөрчилсөн. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 болон 18 дугаар зүйлд <b>газрын нөөц ашигласны төлбөрөөс</b> байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувь хэмжээг тогтооно гэж заасан. Гэтэл “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-д тусгай хамгаалалттай газар нутагт газар ашигласны төлбөрийн орлогын хэсэг гэж заасан нь зөвхөн энэ ангиллын газрын төлбөрөөс л байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийг тооцох мэт зөрчил үүсгэж байсан тул Хуульд нийцүүлж өөрчлөн найруулсан.
2	2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны	2.1. Төсвийн жилийн төлбөрийн орлогын хэсгийг <b>энэ журмын 1.2-т заасан орлогоос</b> Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь, хэмжээ болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлнэ.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлгүй төлөвлөдөг учраас орлогын гүйцэтгэл нь төлөвлөгөөнөөс давж биелдэг. Энэ давсан орлогыг зориулалтын бусаар зарцуулдаг жишиг тогтсон. Тухайлбал 2019 онд орон нутгийн төсөвт байгаль нөөц ашигласны төлбөрөөс 76 тэрбум төгрөгийн орлогыг төлөвлөсөн ч, гүйцэтгэлээр 26.5 тэрбум төгрөгийн давсан орлого төвлөрч зориулалт бусаар зарцуулсан байна.

	иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.		Иймд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсэг нь төлөвлөсөн болон төлөвлөгөөнөөс давсан орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр бүрдүүлэх шинэ агуулгыг оруулж өгсөн.
3	1.2. Энэхүү журмын 2.1-д заасан байгалийн нөөц ашигласны <b>төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх</b> , зохистой ашиглах, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.	3.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь, хэмжээний <b>доод хязгаартай тэнцэх</b> төлбөрийн орлогын хэсгийг <b>тухайн ашигласан нөөцийг</b> хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.	Байгалийн нөөц нь тухайн орон нутгийн байршил, цаг хугацаа, тухайн жилийн онцлогоос хамааран харилцан адилгүй байдаг тул нөөцөөс шалтгаалах төлбөрийн орлого нь тэр хэмжээгээр харилцан адилгүй байдаг. Гэтэл байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа нь цогц байдлаар хэрэгжиж байж үр дүнд хүрдэг учраас зөвхөн тухайн нөөцөөс орсон орлогыг тухайн нөөцөд зарцуулдаг байх зохицуулалтыг өөрчилж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийн хэмжээг уг хуулийн 18.1-т заасан доод хязгаараас дээших хэсгийг бусад нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах боломжийг нээж өгсөн.
		3.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь, хэмжээний доод хязгаараас <b>дээших</b> төлбөрийн орлогын хэсгийг <b>тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр</b> байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.	
4	2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна. Үүнд:	3.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 1.2-т заасан орлогын хэмжээнд үндэслэн төсвийн жилийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна. Үүнд:	Эшлэл хийсэн дугаарын заалт өөрчлөгдсөн.
5	2.2.1. Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээ;	3.3.1. байгалийн ургамлыг хамгаалах, доройтсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээ;	Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээ 1, 2, 4 дүгээрт заасан арга хэмжээнүүд нь орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх зохицуулалтгүй тул өөрчлөн найруулсан.
6	2.2.2. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч хуулийн этгээдтэй зөвшилцөн аймгийн болон агнуурын бүс нутгийн агнуурын	3.3.2. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын саналыг үндэслэн аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	Амьтны тухай хуульд нийцүүлж өөрчлөн найруулсан.

	менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;		
7	2.2.4. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, ойн ангитай зөвшилцөн аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	3.3.3. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага болон ойн ангийн саналыг үндэслэн аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	Ойн тухай хуульд нийцүүлж өөрчлөн найруулсан.
8	2.2.3. усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн “Ус” үндэсний хөтөлбөр, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	3.3.4. аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага болон усны сав газрын захиргааны саналыг үндэслэн сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ;	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлж “Ус” үндэсний хөтөлбөрт үндэслэн гэснийг хасч, өөрчлөн найруулсан.
9	2.2.5. тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаатай зөвшилцөн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн менежментийн тусгагдсан газрын нөхөн сэргээлт, бэлчээрийн менежментийн арга хэмжээ тус тус багтана.	3.3.5. тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа болон менежмент хариуцагч хуулийн этгээдийн саналыг үндэслэн улсын болон орон нутгийн хамгаалалттай газар нутгийн, орчны бүсийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан газрын нөхөн сэргээлт, бэлчээрийн нөхөн ургалтыг сайжруулах арга хэмжээ тус тус багтана.	Менежмент хариуцагч хуулийн этгээдийн саналд үндэслэхийг нэмж оруулсан. Түүнчлэн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт гүйцэтгэх арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болох зохицуулалтыг тусгасан.
10	3.6. Энэхүү журмын 3.1 болон 3.4-т заасан арга хэмжээг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч хуулийн этгээд, байгаль хамгаалах нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	3.16. Байгалийн ургамал, амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нийцүүлж “... аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч хуулийн этгээд, байгаль хамгаалах нөхөрлөл...” гэснийг “... байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл...” гэж өөрчлөн найруулсан.
11	3.7. Энэхүү журмын 3.2-т заасан арга хэмжээг усны сав газрын захиргаатай, 3.3-т заасан арга хэмжээг аймаг, сумын ойн анги, ойн нөхөрлөл, байгаль орчны төрийн бус байгууллагатай, энэ журмын 3.5-д	3.17. Ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг усны сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүлнэ.	Нөөц тус бүрээр салгаж тухайн байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх талуудыг тодорхой тусгасан.
12		3.18. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг сум	

	заасан арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, орчны бүсийн зөвлөлтэй тус тус хамтран хэрэгжүүлнэ.	дундын ойн анги, ойн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	
13		3.19. Газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг, малчид, ойн нөхөрлөл, орчны бүсийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.	
14	4.1. Сум, дүүргийн Засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.	4.1. Сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг 13, 14 дүгээр хавсралтад заасан БНАТ-7, БНАТ-8 маягтын дагуу боловсруулж жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад тус тус хүргүүлнэ.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг батлагдсан маягтын дагуу төлөвлөн гүйцэтгэх, түүнийг цахим мэдээллийн санд байршуулснаар хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, улмаар хуулийн хэрэгжилт сайжрах боломжтой болох юм Иймээс уг заалтыг өөрчлөн найруулсан.
15	4.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	4.2. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага тухайн шатны төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг 15, 16 дугаар хавсралтад заасан БНАТ-9, БНАТ-10 маягтын дагуу боловсруулж жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор нэгтгэнэ.	Аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тайлан, төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлсэн БОХНСАХ-ний тайланг аймгийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага боловсруулах бөгөөд харьяа сум, дүүргүүдийн тайлантай нэгтгэн аймаг, нийслэлийн ИТХ-д хүргүүлэх, Байгаль орчны мэдээллийн сангаар дамжуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шууд хүргүүлэх зохицуулалтыг нэмж тусган өөрчлилсэн.
16		4.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 4.1, 4.2-т заасан тайланг 17, 18 дугаар хавсралтад заасан БНАТ-11, БНАТ-12 маягтын дагуу нэгтгэж жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.	
17	4.5. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын 4.2-т	4.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.3-т заасан тайланд үндэслэн энэ	Орон нутгийн төсвийн төсөлд боловсруулах журамд 4.2 дох хэсгийн заалтанд нийцүүлэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг

	заасан тайланд үнэлгээ өгч, үр дүнд үндэслэн дараа жилд ашиглах байгалийн нөөцийн төрөл, хэмжээнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.	журмын 2.3-т заасан ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.	гурван жилээр буюу дунд хугацаагаар тогтоож өгөх зохицуулалтыг шинээр тусгаж өөрчлөн найруулсан.
18	4.3. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ.	4.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, <b>сум, дүүргийн</b> байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ.	Байгаль орчны мэдээллийн санг ашиглан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, БОХНСАХ-ний зардлын тайланг сум, дүүргийн түвшинд гүйцэтгэх боломжтой тул "... аймаг, нийслэлийн..." гэсний дараа "...сум, дүүргийн ..." гэж нэмж, өөрчлөн найруулсан.
19	4.8. Энэхүү журмын 3.1-3.7 дахь арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ.	4.11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрдүүлнэ.	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй журамд олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ гэж заасан боловч хэн бүрдүүлэх нь тодорхойгүй эзэн биегүй заалт байсныг тодорхой хариуцсан субьекттэй болгож өөрчлөн найруулсан.
<b>Хоёр. Шинээр нэмж оруулсан</b>			
1	-	1.2. Төсвийн жилийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь төсвийн жилд бүрдүүлэхээр төлөвлөсөн болон өмнөх төсвийн жилийн төлөвлөгөөнөөс давсан байгалийн нөөц ашигласны орлогын нийлбэрээс бүрдэнэ.	Төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан гүйцэтгэлийг хуулийн дагуу БОХНСАХ-нд зарцуулах хэсгийг зориулалт бусаар зарцуулдаг нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт доогуур байх үндсэн шалтгаануудын нэг болохыг судалгаагаар тодорхойлсон. Иймээс давсан орлогын хэсгээр БОХНСАХ-г санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх заалт нэмж оруулсан.
2	-	1.3. Төлбөрийн орлогын хэсгийг төлөвлөх, тайлагнахад энэ журмын хавсралтаар батлагдсан маягуудыг ашиглах ба Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг БОХНСАХ-нд зарцуулах үйл явцыг төлөвлөх, тайлагнахад баримтлах нэгдсэн стандарт, тогтолцоо байхгүй нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгааг

		хэсгийн 17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд цахимаар байршуулна.	судалгаагаар тодорхойлсон. Иймд Сум, дүүргийн түвшнээс эхлэх мэдээллийн нэгдсэн тогтолцоо үүсгэх нь төлөвлөлт, тайлагналт, хяналт, үнэлгээг гүйцэтгэх үйл явцыг сайжруулах тул заалт нэмж оруулсан.
3	-	2.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ дараагийн гурван жилд /цаашид “дунд хугацаа” гэх/ ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналаа тухайн байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг нэг жилээр бэлтгэж байгаа нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн жилийн төлөвлөгөөг оновчтой боловсруулахад тохиромжгүй тул Төсвийн тухай хууль... уялдуулан гурван жилээр буюу дунд хугацаагаар тогтоож, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлж байхаар шинэ заалт нэмж оруулсан.
4	-	2.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг дунд хугацаагаар тогтоож жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.	Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг тухайн жилийн төсвийн санал боловсруулахад тусгуулахгүй байгаа нь төлөвлөлтөд сөрөг нөлөө үзүүлж байгааг судалгаагаар тогтоосон. Энэ харилцааг журмаар зохицуулснаар орон нутгийн төсвийн төлөвлөлт нь ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээнд үндэслэгдэх боломжтой болно.
5	-	2.4. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно.	Ашиглах байгалийн нөөцийн төрөл хэмжээний хуваарийг тухай бүр сум, дүүргээр батлан хүргүүлдэг бөгөөд уг хуваарь нь төсвийн цаглабартай нийцдэггүй тул уг нөхцөл байдлыг засварлах зорилгоор шинэ заалт нэмж оруулсан.
6	-	2.5. Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтад заасан БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны -асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.	Сум, дүүргийн түвшинд байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь холбогдох хууль тогтоомжийн талаар ойлголт сул, төсвийн харилцааны талаар мэдлэггүй байх зэрэг шалтгааны улмаас сум, дүүргийг орхигдуулан аймаг, нийслэлийн түвшинд БОХНСАХ-г төлөвлөж байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Иймээс сум, дүүргийн түвшинд хэн, ямар хугацаанд, батлагдсан стандарт маягтын дагуу хэрхэн төлөвлөлт хийхийг тодорхой болгон нэмэлт заалт оруулж өгсөн.

7	-	2.6. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасан орлогын төлөвлөгөөг 5 дугаар хавсралтад заасан БНАТ-3 маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор боловсруулна.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос зарим хэсэг нь аймаг, нийслэлийн төсөвт орохоор зохицуулагдсан байдаг тул журмын төслийн 2.5-д заасантай ижил цаг хугацаанд, хэн, батлагдсан стандарт маягтын дагуу хэрхэн төлөвлөлт хийхийг тодорхой болгон нэмэлт заалт оруулж өгсөн.
8	-	2.7. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага энэ журмын 2.5, 2.6-д заасан орлогын төлөвлөгөөг 9 дүгээр хавсралтад заасан БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж, аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.	Журмын төслийн 2.5, 2.6-д тус тусдаа хийгдсэн төлөвлөлтийг Аймаг, нийслэлийн хэмжээнд стандарт маягтын дагуу нэгтгэж, хэн, ямар цаг хугацаанд гүйцэтгэхийг тодорхой болгож нэмэлт заалт оруулсан.
10	-	3.4. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг төлөвлөхдөө энэ журмын 3.3-т заасныг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ. Үүнд:	Аймаг, нийслэл ба сум, дүүргийн төсвөөр санхүүжүүлэх БОХНСАХ-г төлөвлөхдөө давхардал, хийдэл үүсгэх замаар арга хэмжээний чанар, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсэх магадлалтайг судалгааны үр дүнд тодорхойлсон. Иймээс журмын төслийн 3.4,
11	-	3.5. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг төлөвлөхдөө энэ журмын 3.3-т заасныг үндэслэн, энэ журмын 3.4.4-3.4.6-д зааснаас гадна тухайн сум, дүүргийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих дараах арга хэмжээний зардлыг санхүүжүүлнэ. Үүнд:	3.5-д заасны дагуу орон нутгийн төсвийн шатлал бүрээр санхүүжүүлэх БОХНСАХ-г нэг бүрчлэн тусгасан. Аймаг, нийслэлийн түвшинд 13, сум, дүүргийн түвшинд 17 төрлийн арга хэмжээг гүйцэтгэж болохоор журамласан.
12	-	3.6. Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.4, 3.5-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа үндсэн шалтгаануудын нэг нь төлбөрийн орлогын хэсгийг зориулалт бусаар зарцуулдаг байдал гэж судалгааны үр дүнгээр тодорхойлсон. Иймээс төлбөрийн орлогын хэсгийг зөвхөн зөвшөөрөгдсөн БОХНСАХ-нд зарцуулахаар журамлах нь зориулалт бус зарцуулалтыг хязгаарлах юм.
13	-	3.7. Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг 3 дугаар хавсралтад заасан	Төлбөрийн орлого нь сум, дүүргийн төсөвт төвлөрч байгаа боловч түүгээр санхүүжүүлэх БОХНСАХ нь тухайн сум, дүүргийн хэмжээнд

		БНАТ-2-А маягтын дагуу боловсруулж жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.	төлөвлөгдөхгүй бол дээд шатнаас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг багасгах замаар байгалийн нөөц ашигласныг төлбөрийн орлогыг зориулалт бусаар зарцуулах нөхцөл байдалд хүргэдэг болохыг судалгааны үр дүнгээр тодорхойлсон. Иймээс батлагдсан маягтын дагуу аймаг, нийслэл ба сум, дүүргийн төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-ний төлөвлөгөөг ижил цаг хугацаанд зэрэг гүйцэтгэхээр заасан. Өөр хоорондоо уялдаа бүхий харилцаа биш тул ижил цаг хугацаанд гүйцэтгэх боломжтой.
14	-	3.8. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага энэ журмын 3.4-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг 7 дугаар хавсралтад заасан БНАТ-4-А маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор боловсруулна.	
15	-	3.9. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага энэ журмын 3.7, 3.8-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг 11 дүгээр хавсралтад заасан БНАТ-6-А маягтын дагуу нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.	Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвийг боловсруулах цаглабарын дагуу аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулах байдлаар БОХНСАХ-ний зардлыг тусгуулах нь хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөөтэй болохыг судалгаагаар тодорхойлсон. Иймээс орон нутгийн төсөвт байгаль хамгаалах зардлыг тусгах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг зориулалт бусаар зарцуулж болзошгүй нөхцөл байдлыг хязгаарлах зорилготой заалт оруулсан.
16	-	3.10. Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх энэ журмын 3.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтад заасан БНАТ-2-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг оновчтой төлөвлөөгүй эсхүл төлөвлөх боломжгүй нөхцөл байдлын улмаас байгалийн нөөц ашигласны төлбөрийн давсан орлого үүсдэг болохыг судалгааны үр дүнд тодорхойлсон. Түүнчлэн энэхүү давсан орлогын хэсгийг зориулалт бусаар зарцуулдаг байдал хэвшил болсон. Төлбөрийн орлогын урьдчилсан гүйцэтгэл тооцогдох үед давсан орлогоос хуульд заасан хувь хэмжээний дагуу БОХНСАХ-г төлөвлөн дараа оны орон нутгийн төсвөөр гүйцэтгэх арга хэмжээ болгон оруулах байдлаар тусгах нь үр дүнтэй болохыг судалгаа, хэлэлцүүлгүүдийн үр дүнгээр тодорхойлсон. Иймээс энэ харилцааг батлагдсан маягтын дагуу гүйцэтгэх зохицуулалтыг тусгасан.
17	-	3.11. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх энэ журмын 3.4-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг 8	

		дугаар хавсралтад заасан БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор боловсруулна.	
18	-	3.12. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага энэ журмын 3.10, 3.11-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг 12 дугаар хавсралтад заасан БНАТ-6-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор нэгтгэнэ.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан гүйцэтгэл буюу давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх БОХНСАХ-г тухайн аймаг, нийслэлийн түвшинд нэгтгэснээр дараа оны төсвийн төсөлд хуулийн дагуу тусгах зохицуулалт оруулсан.
19	-	3.13. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага энэ журмын 3.8, 3.11-т заасан арга хэмжээний нэгтгэл төлөвлөгөөг 6 дугаар хавсралтад заасан БНАТ-4 маягтын дагуу, энэ журмын 3.9, 3.12-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг 10 дугаар хавсралтад заасан БНАТ-6 маягтын дагуу тус тус нэгтгэж, төсвийн төсөлд тусгуулахаар жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ.	Аймаг, нийслэлийн төсвийн төсөл боловсруулахад БОХНСАХ-г хуулийн дагуу тусгах харилцааг батлагдсан маягтын дагуу нэгтгэн тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлснээр төсвийн цаглабартай бүрэн уялдах боломжтой болно. Иймээс энэ харилцааг зохицуулах заалт оруулсан.
20	-	3.14. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 3.13-т заасан арга хэмжээний нэгтгэл төлөвлөгөөг төсвийн төсөлд тусган жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж буй төсвийн төсөлд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь хэмжээний дагуу БОХНСАХ-г тусгахгүй байгаа нь уг хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгаа нэг үндсэн шалтгаан болохыг судалгааны үр дүнгээр тодорхойлсон. Иймээс ИТХ-д өргөн мэдүүлж буй тухайн шатны төсвийн төсөлд хуульд заасан хувь хэмжээнээс багагүйгээр БОХНСАХ-г төлөвлөн тусгахаар заасан.
21	-	3.15. Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.7, 3.10-т заасан арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтад заасан БНАТ-2 маягтын дагуу нэгтгэж, төсвийн төсөлд тусган жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.	
22	-	4.4. Энэ журмын 4.3-т заасан тайланг Байгаль хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд бүрэн оруулсан эсэхэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.	Байгаль орчны мэдээллийн сангийн “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан”-г ашиглан тайлагнах, хяналт тавих харилцааг нэмж журамд тусгасан тул хяналт тавих үүргийг нэмж оруулсан.
<b>Гурав. Хэвээр үлдээсэн</b>			

1	4.4. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үнэлгээ хийнэ.	4.7. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үнэлгээ хийнэ.	-
2	4.6. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлого, зарцуулалтыг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээнэ.	4.9. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээнэ.	-
	2.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгана.	4.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгана.	
	2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төсвийн орлогын хэсгийг бүрдүүлэх, төлөвлөх, зарцуулах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангана.	4.10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн орлогын хэсгийг бүрдүүлэх, төлөвлөх, зарцуулах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангана.	
<b>Дөрөв. Хасагдсан</b>			
	3.1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.1-д заасныг үндэслэн тухайн суманд:		

<p>3.2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.3-т заасныг үндэслэн:</p> <p>3.3. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.4-т заасныг үндэслэн:</p> <p>3.4. Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.2-т заасныг үндэслэн тухайн суманд:</p> <p>3.5. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.5-д заасныг үндэслэн:</p>		
---	--	--